


“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дугаар сарын
09-ны өдрийн 4/02 дугаар тоот тушаалын хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 3 дугаар сарын 01-ний өдөр

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан огноо:

2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК

Төлөвлөлт, төсөл хөтөлбөрийн газар

Ажлын байрны нэр:

Ажлын байрны ангилал, зэрэглэл

Ахлах мэргэжилтэн

Гүйцэтгэх

Ажлын байрны албан ёсны байршил:

ТОСК-ийн байр, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, Их тойруу 53/3

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго:

Компанийн гадаад, дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлэх, хэрэгжүүлж байгаа орон сууцны төслүүдийн бэлтгэл ажил, зураг төсөл, төсөв боловсруулах, батлуулах, дэд бүтэц болон орон сууцны барилга, байгууламжийн угсралт түүнийг ашиглалтад оруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж хэрэгжилтийг хангах, шаардлагатай судалгаа дүн шинжилгээг боловсруулах, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоог хангах,

барилгын бүтцийн ажлын зураг, төсөвт хяналт тавих, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянаж, баталгаажуулах, барилгын зургийн зохиогч болон гүйцэтгэгчийн ажлын уялдаа холбоог хангаж, шаардлагатай үед технологи, хийцийн хамтарсан шийдвэр гаргах, байгууллагын эрх ашгийг хамгаалж, барилга угсралтын ажлыг чанартай гүйцэтгүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах, төсөл хариуцсан ажилтнуудын ажлын уялдаа холбоог хангах, төслүүдийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцан ажиллах;

Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд компанийн “Авлигын эсрэг бодлогын баримт бичиг”-т тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг компанийн хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Ажлын байрын зорилт:

1. Компанийн хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж буй төслүүдийн бэлтгэл ажлын хангах
2. Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэгч, гэрээт байгууллагуудын барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, гүйцэтгэлийн чанарт хяналт тавих, удирдан зохион байгуулах;
3. Төслүүдийн дэд бүтэц, төслийн орон сууцны барилга байгууламжийн зураг төсөл, төсөв боловсруулах ажилд хяналт тавих, гүйцэтгэгч хоорондын уялдаа холбоог хангах, холбогдох төрийн байгууллагуудаар батлуулах;
4. Төслүүдийн дэд бүтцийн болон орон сууцны барилга байгууламжийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл төсвийн дагуу гүйцэтгүүлэх ажилд хяналт тавих, гүйцэтгэгч хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах;
5. Төслүүдийн батлагдсан зураг төсөл төсвийн дагуу гүйцэтгэсэн дэд бүтцийн болон орон сууцны барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах;
6. Гадаадын, төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа болон хэрэгжих төслүүдийн хэрэгжилтэд оролцогч талуудын уялдаа холбоог ханган ажиллах.
7. Ерөнхий гүйцэтгэгч, гэрээт байгууллагуудаас ирүүлсэн барилга угсралтын ажлын гүйцэтгэлтийг санхүүжүүлэх журмын дагуу хянаж баталгаажуулах;
8. Компанийн хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутагт баригдаж байгаа орон сууцны барилгыг орон нутгийн гэрээт хяналтын инженерээс тухай бүр тайлан мэдээ гаргуулан авч нэгтгэх, барилга угсралтын үе шатны ажлын явц, тулгарч байгаа асуудлын талаар удирдлагад мэдээлж, шуурхай удирдлагаар хангаж шийдвэрлүүлэх;
9. Барилгын тухай хууль болон Барилгын норм ба дүрэм болон бусад дүрэм журам стандартыг баримтлан ажиллах, шаардлагатай зөвшөөрөл бусад баримт бичиг боловсруулах, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн инженерийн тооцоо, техникийн шийдлүүдийн үндэслэл, төлөвлөгөө, тайланг гаргах;
10. Зураг төслийн зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан гаргуулж хянах, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцох, баримтыг боловсруулах, тайлагнах;
11. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууц, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх орон сууцны батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;
12. Бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Ажлын байрын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх - Г Хянах - Х
--------	----------------------------------	-------------------------------	---

			Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Компанийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх төслүүдийн бэлтгэл ажлын хүрээнд төслийн суурь судалгаа, урьдчилсан төлөвлөлт боловсруулах;	Компанийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх төслүүдийн бэлтгэл ажлын хүрээнд төслийн суурь судалгаа, урьдчилсан төлөвлөлт боловсруулж ажилласан байна.	Г
	Шаардлагатай тохиолдолд төслүүдийн талбайг чөлөөлөх, талбайг бэлтгэх, талбайн аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг бүрдүүлэх, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулах;	Төслүүдийн талбайг бэлтгэх, талбайн аюулгүй байдлыг хангаж баримт бичгийн бүрдлийг хангах, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж ажилласан байна.	Г
	Хэрэгжихээр төлөвлөгдөж буй төсөл хөтөлбөрүүдийн судалгаа, төсөв тооцооллыг хийлгэж газрын даргад танилцуулан, байгууллагын төсөвт суулгах ажлыг зохион байгуулах	Хэрэгжих төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой бэлтгэл ажлын зардал байгууллагын төсөвт суусан байна	Г
2 дугаар зорилтын хүрээнд	Компаниас хэрэгжүүлэх төслүүдийн инженер техникийн шийдлүүдийн талаар шинжилгээ, судалгаа хийх, үндэслэлийг боловсруулан төслийн удирдагчаар хянуулж, газрын даргад танилцуулан хүлээлгэн өгөх;	Компаниас хэрэгжүүлж буй төслүүдийн инженер техникийн шийдлүүдийн талаар шинжилгээ, судалгаа хийн үндэслэлийг боловсруулж, холбогдох ажилтанд хүлээлгэж өгсөн байна.	Г
	Хэрэгжиж буй төслүүдэд компаны, Нийслэлийн, Улсын төсвийн санхүүжилтээр хийгдэхээр гэрээнд туссан ажил, үйлчилгээний тооцооллыг хийх, холбогдох төсөвт суулгах саналыг боловсруулан удирдлагад танилцуулах.	Улс, Нийслэл болон компаны санхүүжилтээр хийгдэхээр гэрээнд туссан ажлууд хийгдсэн байна.	Г
	Компаниас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урт богино хугацааны төлөвлөгөөг боловсруулах, тайлан гаргахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт материалыг холбогдох байгууллага, гүйцэтгэгч	Холбогдох тооцоо судалгааг боловсруулсан байна.	Г

	нараас гаргуулан авч нэгтгэж тооцоо, судалгааг боловсруулах;		
3 дугаар зорилтын хүрээнд	Төслүүдийн дэд бүтцийн болон орон сууцны барилга байгууламжийн холбогдох зураг төсөл, төсөв боловсруулах ажилд тогтмол хяналт тавих;	Компанийн хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх төслүүдийн зураг төсөл, төсөв боловсруулах ажилд хяналт тавин ажилласан байна.	Г
	Гүйцэтгэгч талуудын уялдаа холбоог хангаж ажиллах, холбогдох хууль, журам, норм дүрмийн шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэгч байгууллагуудын уялдаа холбоог хангаж, холбогдох хууль, журам, норм дүрмийн шаардлагыг хангуулж ажилласан байна.	Г
	Зураг төсөл, төсвийг магадлалд оруулан батлуулах ажлыг зохион байгуулах;	Зураг төсөл төсвийг магадлалд оруулан батлуулах ажлыг зохион байгуулсан байна.	Г
	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулах, холбогдох, хууль, журам, дүрэм, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж, холбогдох хууль, журам, дүрэм, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	Төслүүдийн дэд бүтцийн болон орон сууцны барилга байгууламжийн угсралтын ажилд хяналт тавих;	Төслүүдийн дэд бүтцийн болон орон сууцны барилгын угсралтын ажилд хяналт тавьж ажилласан байна.	Г
	Гүйцэтгэгч талуудын уялдаа холбоог хангаж ажиллах;	Гүйцэтгэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангаж ажилласан байна.	Г
	Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандартын шаардлагыг хангуулах ажлыг хариуцах;	Холбогдох хууль, журам, норм дүрмийн шаардлагыг хангуулж ажилласан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	Төслүүдийн бүх шатны барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах;	Төслүүдийн бүх шатны барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангаж, улсын комисст хүлээлгэн өгсөн байна.	Г

	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулах, холбогдох хууль, журам, дүрэм, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулах, холбогдох хууль, журам, дүрэм, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	Гадаадын төрийн болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын зээл, тусламж бусад санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэх төслүүдийн оролцогч талуудын уялдаа холбоог хангаж ажиллах;	Төслүүдийн оролцогч талууд хоорондын уялдаа холбоог хангаж ажилласан байна.	Г
	Туршлага судлах, мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах, үр дүнг төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад ашиглах;	Холбогдох ажлыг зохион байгуулж үр дүнг тооцсон байна.	Г
7 дугаар зорилтын хүрээнд	Орон сууцны барилгын ажлын зураг төсөл, төсөв боловсруулах явцад хяналт тавих, иж бүрдлүүдийг хянаж холбогдох санал, дүгнэлтийг тусгаж ажиллах;	Орон сууцны барилгын ажлын зураг төсөл, төсөв боловсруулах явцад хяналт тавьж иж бүрдлүүдийг хянан, санал дүгнэлтээ гаргаж, тусгуулсан байна.	Г
	Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, бусад бичиг баримтыг бүрдүүлж ажиллах;	Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг авч шаардлагатай бичиг баримтын бүрдлийг хангасан байна.	Г
8 дугаар зорилтын хүрээнд	Зураг төсөл зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан, дүгнэлтийг гаргуулж авах;	Зураг төсөл зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан, дүгнэлтийг гаргуулан авсан байна.	Г
	Барилгын үе шатны ажлыг актаар тухай бүрд баталгаажуулж барилга ашиглалтад оруулах комиссуудын бүрэлдэхүүнд орж ажиллах;	Барилгын үе шатны ажлыг актаар цаг тухайд нь баталгаажуулж, барилга ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр орж ажилласан байна.	Г
9 дүгээр зорилтын	Барилгын ажлын явцын мэдээг тухай бүрд гарган угсралтын тодорхой хувьд хүрсэн болон	Барилгын угсралтын ажлын явцын тайлан мэдээ гаргаж шаардлагатай тохиолдолд	Г

хүрээнд	шаардлагатай тохиолдолд барилга угсралтын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах;	барилга угсралтын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулсан байна.	
	Төсөл хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Төсөл хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг өсгөх чиглэлээр дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх арга хэмжээг судлан зохион байгуулсан байна.	Г
10 дугаар зорилтын хүрээнд	Зураг төслийн зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан гаргуулж хянах;	Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд зураг төслийн зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан гаргуулж тайлагнасан байна	Г
	Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцох, баримтыг боловсруулах, тайлагнах	Төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулсан байна	Г
11 дүгээр зорилтын хүрээнд	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх орон сууцны батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна	Г
Ажлын байрны бусад зорилтын хүрээнд	Компаниас гаргасан дүрэм, журам, заавар, Гүйцэтгэх захирлын тушаал, захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, шуурхайн үүрэг, даалгавар, шууд удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг зохих шаардлагын дагуу биелүүлэх;	Үүрэг даалгаврыг биелүүлсэн байна.	Г
	Авилгын эсрэг хууль тогтоомж, компанийн “Авлигийн эсрэг бодлогын баримт бичиг” төлөвлөгөөнд тусгагдсан болон Хөдөлмөрийн дотоод журам, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээнд заасан ажлуудыг хийж, хэрэгжүүлэх;	Авилгын эсрэг хууль тогтоомж, компанийн “Авлигийн эсрэг бодлогын баримт бичиг” төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн дотоод журам, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээнд заасан авлигын эсрэг	Г

		холбогдох ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.	
	Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох байгууллагаас ирүүлсэн удирдамж, баталсан хуваарийн дагуу хийж буй хяналт, шалгалтад шаардлагатай баримт материалыг заасан хугацаанд нь түргэн шуурхай гаргаж өгч бусдад хүндрэл чирэгдэл учруулахгүй ажиллах;	Шаардлагатай баримт, мэдээллийг заасан хугацаанд өгсөн байна.	Г
	Ажлаас чөлөөлөгдөх болон албан тушаал өөрчлөгдөх тохиолдолд эрхэлж байсан ажилтай холбоотой үүссэн цаасан, цахим, тусгай төрлийн баримт бичгийг тухайн онд батлагдсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу холбогдох ажилтанд хүлээлгэн өгөх;	Акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна.	Г
	Ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглаж, ажлын цагаар ажлаар явах болон түр эзгүй байх үед цагаа бүртгүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх, ажилд ирэх, ажил дуусаж гарахдаа өөрийн биеэр цагаа бүртгүүлж байх, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах;	Ажлын цагаа үр бүтээлтэй ашиглаж, батлагдсан ажлын цагийн хуваарийн дагуу ирцээ цаг тухай бүрт нь бүртгүүлсэн байна.	Г
	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хангаж ажиллах;	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хангаж ажилласан байна.	Г
III. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Архитектур /073104/, Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер /0732/		
Мэргэшил	Мэргэжлээрээ мэргэшсэн байх		
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх		

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Компанийн чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах.

IV. АЖИЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Ажилтныг шууд харьяалан удирдах Ажлын байрны нэр:

Төлөвлөлт, төсөл хөтөлбөрийн газрын дарга


Ажилтны шууд харьяалан удирдуулах ажлын байрны нэр, тоо:

Нийт: 14

- Барилгын захиалагч, хяналтын хэлтэс
 - Ерөнхий инженер
 - Инженер, эдийн засагч
 - Хяналтын инженер
- Солонго төслийн нэгжийн инженерүүд
- Төслийн мэргэжилтэн

Бусад харилцах субъект:

1. Хот Байгуулалт, Барилга Орон Сууцжуулалтын Яам
2. Сангийн яам
3. Хот байгуулалт, хөгжлийн газар
4. Аймаг, Нийслэлийн төрийн байгууллагуудын холбогдох нэгжүүд
5. Орон нутгийн Барилга захиалагчийн албад
6. Инженерийн шугам сүлжээний хангагч

	байгууллагууд 7. Бусад харилцагч аж ахуйн нэгж байгууллагууд	
Ажилтны хүлээх хариуцлага	- Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг хэрэгжүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасан хариуцлага хүлээнэ.	
Ажлын байрны нөөц, хэрэгсэл	Санхүү	- Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан үндсэн цалин, удаан жилийн нэмэгдэл, Хөдөлмөрийн хууль болон хамтын гэрээнд заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.
	Материалын	- Албан ерөөний тавилга, эд хогшил, компьютер, холбогдох техник хэрэгсэл - Албан хэрэг хөтлөлтийн програм хангамж
	Бусад	- Ажил хэргийн холбогдолтой ном, гарын авлага - Компанийн вэб сайт, цахим мэдээллийн хэрэгслүүд, дотоод сүлжээ ашиглах;
V.АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:		
Албан тушаал: "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч		
 <p>Гарын үсэг: Б.ЛХАГВА-ОЧИР 9019110863 ☎ 5745535</p>		
Ажлын байрны тодорхойлолтыг танилцуулсан:	Ажлын байрны тодорхойлолттой танилцсан:	
Албан тушаал:	Ахлах мэргэжилтэн	
..... () <u>гарын үсгийн тайлал</u> () <u>гарын үсгийн тайлал</u>	
Огноо:	Огноо:	

